

**Прокурорын сонсгосон ял хуульд нийцээгүй
тул хэргийг прокурорт буцаав.**

Шүүгчийн захирамжийн дугаар: 2023/ШЗ/09

Шийдвэрийн төлөв: Хүчин төгөлдөр болоогүй

Захирамжийн хураангуй: 2022.12.27

Шүүгдэгч төрийн албан хаагч Н нь 2022 оны 08 дугаар сарын 07-ны өдөр Завхан аймгийн Баянтэс сумын Жавхлан багийн нутаг “Гурван халзан” гэх газарт зохих зөвшөөрөлгүйгээр 1.4 метр куб түлшний мод бэлтгэж, сумын ойн санд 153,664 төгрөгийн хохирол учруулсан, мөн босоо модыг хөрөөдөж унагах явцад Д-ийн толгойн тус газарт нь хөрөөдсөн модны үзүүр хэсэг цохиж эрүүл мэндэд нь хүнд хохирол болгоомжгүйгээр учруулсан гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Прокуророос шүүгдэгч Н-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хорих ял оногдуулахгүйгээр 1 жилийн хугацаагаар тэнсэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-д заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.4-т зааснаар хорих ял оногдуулахгүйгээр 1 жил, 6 сарын хугацаагаар тэнсэж, тэнсэх хугацааг нэмж нэгтгэн 2 жил, 6 сарын хугацаагаар тогтоож, үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авах саналтай, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээр шүүхэд ирүүлсэн байна.

Шүүх шүүгдэгч Н-д холбогдох эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд прокурорын сонсгосон ял, албадлагын арга хэмжээ нь хуульд нийцээгүй гэж үзэж хэргийг прокурорт буцааж шийдвэрлэсэн.

Тодруулбал: Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах ялыг заавал оногдуулна” гэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахдаа гэмт хэрэг тус бүрд ял оногдуулж нэмж нэгтгэн нийт эдлэх ялын төрөл, хэмжээг тогтооно” гэж тус тус хуульчилсан байтал прокурор ямар эрхийг ямар хугацаагаар хасах талаар саналдаа тусгаж сонсгоогүй, хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн гэх шүүгдэгч Н-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан хорих ял оногдуулахгүйгээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 1 жил, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.4-т зааснаар 1 жил, 6 сарын хугацаагаар тус тус тэнсэж, нэмж нэгтгэн 2 жил, 6 сарын хугацаагаар тогтоож тэнссэн хугацааг ял нэмж нэгтгэх байдлаар нэгтгэсэн нь хуульд нийцээгүй гэж үзэв.

Хураангуйг бэлтгэсэн: Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгч Б.Өлзийхишиг